

1991 ОНЫ МОНГОЛ-АМЕРИКИЙН ХАРИЛЦААНЫ ТОЙМ

1-р сар

— Шинэ жилийн эхний өдөр Монгол орны соёлын амьдралд нэгэн чухал үйл явдал болж, Монголын телевиз үзэгчид 13 цагийн зөрөөтэй хол оршдог АНУ-ын телевизийн «Уолт нэт» сувгийн нэвтрүүлгийг хүлээн авч үзэх болов. 1991 оны 1-р сарын 1-нээс АНУ-ын телевизийн нэвтрүүлгийг Монгол улсад хүлээн авч үзэх ёслолын ажиллагаа Монголын телевизийн нэвтрүүлгийн их танхимд болов. Тус нэвтрүүлгийн эхэнд АНУ-ын төрийн нарийн бичгийн дарга Жеймс Бейкер Монголын үзэгчдэд хандаж хэлсэн үгэндээ Америкийн телевизийн нэвтрүүлгийг хүлээн авч үзэх сайхан боломжтой болж байгаа нь манай 2 орны ард түмний найрамдлыг бэхжүүлэх, бие биеэ улам гүнзгий ойлгож мэдэхэд тус дөхөм болсон чухал үйл явдал мөн гээд ардчиллаа гүнзгийрүүлж, зах зээлийн эдийн засагт амжилттай шилжин ороход тань тусламж дэмжлэг үзүүлэхэд бэлэн байна» гэлээ.

— «Худалдааг дэмжих хоёр талын ажлын хэсэг байгуулах тухай» БНМАУ-ын Засгийн газар, АНУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг БНМАУ-ын Засгийн газрын хуралдаанаар зөвшөөрч уг хэлэлцээрт гарын үсэг зурах эрхийг худалдаа, үйлдвэрийн сайд С. Баярбаатарт олгохоор шийдвэрлэв.

— Худалдаа, аж үйлдвэрийн танхимд АНУ, БНМАУ-ын үйлдвэр, хоршоо, пүүс олон нийтийн байгууллага болон иргэдийн санаачилгаар «АНУ-Монгол худалдааны зөвлөл» хэмээх олон нийтийн байгууллагын зохион байгуулах хурал болов.

— АНУ-аас БНМАУ-д үзүүлж байгаа техникийн туслалцааны хүрээнд Монгол улс зах зээлийн эдийн засагт шилжиж байгаатай хол богдуулан дотоодын хууль тогтоомжийг боловсронгуй болгох асуудлаар АНУ-ын Мэрилэндийн их сургуулийн профессор, хуульч Ч. А. Казвели, эдийн засагч П. Нурелл, АНУ-ын олон улсын хөгжлийн агентлагийн газрын орлогч дарга Д. Блейн нар оролцсон семинар болов.

— АНУ-ын Ерөнхийлөгч Жорж Бушийн урилгаар БНМАУ-ын Ерөнхийлөгч П.Очирбат гэргийн хамт 1-р сарын 20—24-нд АНУ-д албан ёсны ажлын айлчлал хийв. БНМАУ-ын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд БНМАУ-ын Засгийн газрын шадар сайд Ч. Пүрэвдорж, Гадаад харилцааны сайд Ц. Гомбосүрэн, Худалдаа үйлдвэрийн сайд С.Баярбаатар, Ерөнхийлөгчийн улс төр, гадаад харилцааны асуудал эрхэлсэн зөвлөх Л. Баярт нар оров.

— Ерөнхийлөгч П.Очирбатад АНУ-ын Азийн фондын ерөнхийлөгч ноён У. Фуллер, 1-р сарын 21-нд бараалхаж, Америк, Монголын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд зуучлах хүсэлтээ илэрхийлж санал солилцов. П. Очирбатыг «Улс хооронд ойлголцохын төлөө зөвлөлийн ерөнхийлөгч Ш. Паулексе хүлээн авч уулзав. Уулзалтад «Боинг» нисэх онгоцны пүүс, цэрэг, худалдаа, аж үйлдвэрийн хэд хэдэн газрын удирдлага оролцож, БНМАУ болон тэдгээр пүүсийн хооронд хамтран ажиллах талаар ярилцав.

— 1-р сарын 23-нд цагаан ордонд болсон БНМАУ, АНУ-ын хэлэлцээний үеэр П. Очирбат БНМАУ-ын дотоод байдлын талаар тодорхой мэдээлэв. БНМАУ, АНУ-тай хамтран ажиллах сонирхолтой байгааг

П. Очирбат тэмдэглээд, хөдөө аж ахуйд биотехнологийг хөгжүүлэх, зах зээлд шилжих боловсон хүчин бэлтгэх, газрын тос олборлож ашиглах, тоон мэдээллийн олон улсын сүлжээнд нэгдэхэд хамтран ажиллах, Монголд худалдаа аж үйлдвэрийн хөрөнгө оруулалтын дэмжих зэрэг асуудлаар АНУ-ын Засгийн газраас анхаарч дэмжинэ гэдэгт найдаж байгаагаа илэрхийлэв. Нөхөр П. Очирбат Жорж Бушийг гэргийн хамт Монголд айлчлахыг урив. АНУ-ын Ерөнхийлөгч Ж. Буш урилгыг талархан хүлээн авлаа.

Монгол оронтой хамтран ажиллахад нэн тааламжтай нөхцөл бүрдүүлэхийг хүссэн захидлаа өнөөдөр АНУ-ын конгресст илгээнэ. Үүний конгресс баталж, хоёр орны худалдааны болон шинжлэх ухаан-техникийн салбарт хамтран ажиллах хэлэлцээрүүдэд гарын үсэг зурсан нөхцөлд АНУ, БНМАУ хоёр үр ашигтай хамтран ажиллах, Монгол орон зах зээлд шилжихэд тус дөхөм болно гэж найдаж байна. Эдийн засгийн шинэчлэл хийхдээ хувийн үйлдвэрийн салбарыг дэмжих нь чухал. Хувийн хэд хэдэн пүүс хоорондоо өрсөлдөн ажилласнаар Монгол дахь газрын тосыг түргэн хугацаанд хайж олох, Дэлхийн банк, Аж үйлдвэрийн банк зэрэг олон улсын байгууллагад элсэн орох нь Монгол улсын эдийн засгийг хөгжүүлэхэд ихээхэн ач холбогдолтой юм гэж АНУ-ын Ерөнхийлөгч онцлон тэмдэглэв.

— БНМАУ, АНУ хоёр шинжлэх ухаан, техникийн салбарт хамтран ажиллах Засгийн газар хоорондын хэлэлцээрт Гадаад харилцааны сайд Ц. Гомбосүрэн, АНУ-ын төрийн нарийн бичгийн дарга Ж. Бейкер нар Төрийн департаментад гарын үсэг зурав.

— БНМАУ, АНУ-ын засгийн газар хоорондын худалдааны хэлэлцээрт БНМАУ-ын Худалдаа, үйлдвэрийн сайд С. Баярбаатар, АНУ-ын Худалдааны төлөөлөгчдийн газрын дарга, элчин сайд хатагтай Карла А. Хиллс нар Вашингтон хотноо 1-р сарын 23-нд гарын үсэг зурав.

Мөн худалдааг дэмжих хоёр улсын хоорондын ажлын хамтарсан групп байгуулах тухай хэлэлцээрт сайд С. Баярбаатар, АНУ-ын худалдааны нарийн бичгийн дарга Р. Мосбэкер нар гарын үсэг зурав. Хамтарсан группийн анхны хуралдаан болж, хэд хэдэн тодорхой асуудал хэлэлцэв.

— Энх тайвны корпусын БНМАУ-д суугаа төлөөлөгчдийн газрын дарга Ч. Хоувел, ажилтан Х. Гай нарыг БНМАУ-ын Эрүүл мэндийн сайд П. Нямдаваа хүлээн авч уулзах үеэр манай эрүүлийг хамгаалах салбарт ажиллах англи хэл, цахим тоолуурын багш нарыг 6-р сард Монголд ирүүлэхээр тохиролцов.

2-р сар

— АНУ-д үйлдвэрлэсэн «Боинг-757» хоёр онгоцыг онгоц түрээслэгч «Хей Пи Эй» пүүсээс 1992 оны 8, 9-р сард авах худалдааны хэлэлцээрт МИАТ нэгтгэлийн 1-р орлогч захирал М. Дагва, «Ки Пи Эй» пүүсийн Ази, Номхон далайн бүс хариуцсан ерөнхийлөгч Жим Боришли нар гарын үсэг зурав. Энэ онгоц 186 хүний суудалтай, цагт 850 км хурдтай юм. Онгоцны экипажийг сургах, сэлбэгийг хөнгөлттэй нөхцөлөөр авах асуудал онгоцны үнэд багтав.

— Америкийн Азийн фондын шугамаар БНМАУ-ын Бага Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга С. Баяр тэргүүтэй төлөөлөгчид АНУ-д айлчлав. Төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд парламентийн дөрвөн намын төлөөлөгчид оров.

— Монголын Америк судлалын Төвийн гишүүдийн анхдугаар хурал болов. Уг хурлаас Төвийн зохион байгуулалтыг өөрчилж, нэрийг нь «АНУ судлалын Монгол төв» хэмээн тогтож, төвийн тэргүүнээр

ШУА-ийн сурвалжлагч гишүүн, доктор, профессор Н. Ишжамцыг сонгов.

3-р сар

— Монгол Америкийн хамтарсан «Монгол-Амикал» үйлдвэрийн зураг төслийн ажил эхлэв. 1993 онд ашиглалтанд орох энэ үйлдвэр жилд 750-800 т тэмээний эм ноос боловсруулж, ноосон даавуу, сүлжмэл эдлэл үйлдвэрлэх юм. «Монгол тэмээ» пүүс, үйлдвэрийн тоног төхөөрөмжийг Америкийн ижил төстэй үйлдвэр, пүүсээс худалдан авч суурилуулан, түүхий эдээ Америкийн технологиор боловсруулж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ.

— Засгийн газрын хуралдаанаас «Монголын газрын тос»-пүүсээс АНУ-ын «СОАИ» пүүстэй байгуулсан «БНМАУ-д газрын тосны үйл ажиллагааг хамтран явуулах тухай» хэлэлцээрийг зүйтэй гэж үзэв, Энэ пүүстэй хамтран ажилласнаар «Монголын газрын тос» пүүс ойрын жилүүдэд өөрийн хүчээр газрын тос хайлж, олборлон боловсруулж, улмаар дотоодын хэрэгцээг хангах юм.

БНМАУ-ын Засгийн газрын шадар сайд Ч. Пүрэвдорж АНУ-ын уул уурхай-геологи хайгуулын «Амиеке» пүүсийн төлөөлөгчидтэй уулзаж геологийн салбар дахь хамтын ажиллагааны талаар ярилцав. Мөн АНУ-ын «Дизайн супер вижн— групп» пүүсийн менежер Эрдэнэдорж Айкович хүлээн авч уулзав.

— 3-р сарын 12-нд АНУ-ын Конгрессын хоёр танхимаас хамтран Монголын талаар тогтоол гаргав. Уг тогтоолд, 1-рт, чөлөөт бөгөөд шударга сонгууль явуулсан Монголын ард түмэнд баяр хүргэж, бүс нутгийн тогтвортой байдал, худалдаа, хүний эрх зэрэг хоёр талын ашиг сонирхолд нийцсэн асуудлаар Америк-Монголын харилцааг өргөжүүлэн хөгжүүлэхийг эрмэлзэнэ. 2-рт, Монгол улс, түүний ард түмэнд техник, эдийн засгийн бололцоотой бүхий л туслалцаа үргэлжлүүлж үзүүлэхийг АНУ-ын Засгийн газар уриалж байна, 3-рт, Монгол улс эрх чөлөөт улс үндэстний гэр бүлд орж буйд баяр хүргэж байна гэжээ.

4-р сар

— БНМАУ-ын Ерөнхий сайд Д. Бямбасүрэн АНУ-ын Гарвардын их сургуулийн профессор Ж. Загс, Калифорни—Девисийн эдийн засгийн их сургуулийн профессор Вин Ти Ву нартай уулзаж өмч хувьчлалын асуудлаар санал солилцов. Профессор Загс Улсын Бага Хурлын гишүүдэд Монгол орныг эдийн засгийн бэрхшээлээс гаргах, зах зээлд шилжүүлэх арга замын талаар лекц уншив. Мөн Ж. Загс, Вин Ти Ву нар БНМАУ-ын Ерөнхийлөгч П. Очирбаттай уулзаж улс орны эдийн засгийн тулгамдсан асуудлыг хөндөж яриу. Профессор Загс эдийн засгийн шинэчлэлийг аль болох хугацаа хожиж хийвэл хямралаас төдий чинээ түргэн гарна гээд, зах зээлд шилжихдээ өмчийг хувьчлах, үнийг чөлөөтэй болгох, төгрөгийг хөрвөдөг болгохын чухлыг дурдлаа.

— АНУ-ын Засгийн газраас манай орны хүнсний хангамжийг сайжруулахад туслах зорилгоор буцалтгүй тусламж болгон 30 мянган тонн улаан буудай өгөхөөр шийдвэрлэв. Ачих, тээвэрлэх, буулгах бүх зардлыг (9 сая долларын) АНУ-ын тал дангаар даах болно.

5-р сар

— АНУ-ын Аризона муж улсын Бенсен хотын Дэлхийн их сургуулийн Олон улсын нарийн бичгийн дарга нарын газар Монголын нэрт яруу найрагч Бавуугийн Лхагвасүрэнд утга зохиолын салбар дахь соёлын доктор цол олгов.

— БНМАУ-д дулааны цахилгаан станцыг тэргүүний техник технологиор шинэчлэх техник-эдийн засгийн үндэслэл боловсруулахад АНУ-

аас санхүүгийн тусламж авах хэлэлцээрт эрчим хүчний сайд Б. Жигжид гарын үсэг зурав. АНУ-ын худалдаа хөгжлийн хөтөлдөрийн газраас 600 мянган долларын нэмэлт хөрөнгө гаргахаар шийдвэрлэв.

— АНУ-ын Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд Жозеф Леик Техас мужийн хүүхдүүдээс Монголын анд найз нартаа илгээсэн 1000 гаруй номыг Улаанбаатар хотын хүүхдийн номын санд бэлэглэв.

— БНМАУ-ын Худалдаа, үйлдвэрийн сайд С. Баярбаатар, АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн захирал Р. Роскенд нар 30 мянган тонн улаан буудай буцалтгүй тусламж болгон нийлүүлэх шийдвэрийг хэрэгжүүлэх хэлэлцээрт 5-р сарын 16-нд Вашингтон хотноо гарын үсэг зурав.

6-р сар

— АНУ-ын англи хэлний дээд сургууль болон энх тайвны корпусын шугамаар ирэх багш нар англи хэлний дугуйлан, сонгон суралцах ангийн нийт 634 багшид 7-р сараас эхлэн англи хэлний хичээл заана.

— АНУ-ын Энх тайвны корпусын захирал Чук Ховел, БНМАУ-ын шадар сайд Д. Дорлигжав нар тус корпус Монголд үйл ажиллагаагаа явуулж эхэлсэнтэй холбогдуулан уулзаж, Монголд явагдаж байгаа өөрчлөлт, шинэчлэлийн талаар ярилцав.

-- БНМАУ-ын Ерөнхий сайд Д. Бямбасүрэн АНУ-д хийсэн ажлын аяллын үеэр Төрийн нарийн бичгийн дарга Ж. Бейкер, Олон улсын эдийн засгийн байгууллага, Дэлхийн банк, Олон улсын валютын сангийн удирдлага болон АНУ-ын Төрийн байгууллагын удирдах хүмүүстэй уулзаж, санал бодлоо өргөн хүрээнд солилцож, хөгжилтэй долоон орны удирдагчдын зөвлөгөөн дээр Монголын тухай асуудлыг хөндөж ярилцахыг хүсэв. Вашингтонд уулзсан хүмүүс Монгол орны өнөөгийн үйл амьдралын талаар сонсож, дэмжлэг туслалцаа үзүүлнэ гэж мэдэгдэв. АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга АНУ-аас Монголд үзүүлэх тусламж дэмжлэгээ нэмэгдүүлнэ гэж хэлэв.

— Засгийн газрын шадар сайд Ч. Пүрэвдорж АНУ-ын «Моррисон Кнүдсон» корпорацийн дэд ерөнхийлөгч Жон Уэйлэн тэргүүтэй төлөөлөгчидтэй уулзаж, уул уурхайн салбарт хамтран ажиллах төслийг хэрэгжүүлэх, санхүүжүүлэх асуудлаар ярилцав.

— БНМАУ-ын Шинжлэх Ухааны Академи АНУ-ын Үндэсний Шинжлэх Ухааны Академийн хооронд шинжлэх ухааны салбарт хамтран ажиллах хэлэлцээрт Улаанбаатар хотноо гарын үсэг зурав.

7-р сар

— АНУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжийн эхний хэсэг 4250 т гурил, 500 т улаан буудай ирж, гурилын хангамж дутагдалтай байгаа үед манай хүнсний хангамжийг сайжруулахад хувь нэмэр болов.

— АНУ-ын Эксплорейшн Ассошиэйте Интернэйшнл (ЭАИ) пүүстэй хамтран Монголд хийгдсэн газрын тосны судалгааны тайланг судалж нэгтгэн нутаг дэвсгэрийн нефть жилийн байдлыг үнэлэх, сэдэвчилсэн ажил гүйцэтгэж байна.

Гадаадын 10 пүүс манай оронд геологи, геофизикийн судалгаа хамтран явуулах, техникийн зөвлөхөөр ажиллах, ажил үйлчилгээ хийх, аз турших нөхцөлөөр талбай авч ажиллах сонирхолтойгоо илэрхийлэв.

БНМАУ-ын Засгийн газар тус орны нутаг дэвсгэрт тус бүр нь 10—50 мянган км арав гаруй талбайг тодорхойлон тогтоож, гадаадын компаниудад зарлахыг Монгол газрын тос нэгтгэлд зөвшөөрөв.

— Олон улсын хүүхдийн амралтын төвд олон улсын хүүхдийн зуслангийн нээлтийн ёслол болж АНУ-ын хүүхдүүд анх удаа амрахаар ирэв.

— АНУ-ын Засгийн газраас манай ард түмэнд бэлэг болгож байгаа эмнэлгийн барааны эхний хэсэг ирэв. 150 мянган долларын өртөг бүхий 39 мянган фунт жинтэй барааны дотор хордлого тайлагч шингэн, ороох боох материал, эмнэлгийн зориулалттай жижиг багаж хэрэгсэл оров.

— БНМАУ-ын Засгийн газрын урилгаар манай улсад АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Ж. Бейкер 7-р сарын 25-29-нд айлчлал хийв. Айлчлал хийх үеэр Төрийн нарийн бичгийн дарга Ж. Бейкер БНМАУ-ын Ерөнхийлөгч П.Очирбатад бараалхав. Ерөнхийлөгч П. Очирбат Монгол орны улс төр, эдийн засгийн байдлын талаар дэлгэрэнгүй ярилаа. Ноён Ж. Бейкер Ерөнхийлөгч Ж. Бушийн мэндчилгээг П. Очирбатад уламжилж, монголчуудын улс төрийн шилжилтийн асуудлыг тэмдэглээд дэлхийн хөгжилтэй орнууд, Дэлхийн банк, Олон улсын валютын сан зэргээс Монголд туслалцаа үзүүлнэ гэдэгт итгэж байгаагаа илэрхийлэв. Ноён Ж. Бейкер Засгийн газрын ордонд БНМАУ-ын Ардын Их Хурлын депутат, Улсын Бага Хурлын болон Засгийн газрын гишүүдтэй уулзаж дэлгэрэнгүй үг хэлэхдээ АНУ болон адил бодолтой бусад улс гүрэн Монголын ардчилал, чөлөөт зах зээлд хүрэх шилжилтийг амжилттай болгоход тал бүрийн хүч чармайлт тавьж байгаагаа илэрхийлэв.

БНМАУ-ын Ерөнхий сайд Д. Бямбасүрэн АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Ж. Бейкерийг хүлээн авч уулзан, өөрчлөлт, шинэчлэлтийг хэрэгжүүлэх явцад гарч буй ололт амжилт, тохиолдож байгаа бэрхшээлийн талаар тодорхой яриу. Уулзалтын явцад нөхөр Д. Бямбасүрэн, ноён Ж. Бейкер нар БНМАУ, АНУ-ын харилцаа, хамтын ажиллагааны цаашдын хөгжлийн асуудлаар санал бодлоо солилцов.

БНМАУ-ын Гадаад харилцааны сайд Ц. Гомбосүрэн АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Ж. Бейкер нар хэлэлцээ хийж, хоёр талын харилцааг цаашид хөгжүүлэх талаар тодорхой асуудлаар санал солилцов.

— Ноён Ж. Бейкер гэргий болон дагалдан яваа хүмүүсийнхээ хамт Өмнөговь аймагт зочлов.

— 7-р сарын 29-нд Улаанбаатар дахь АНУ-ын Элчин сайдын яамны албан ёсны нээлтийн ажиллагаа дээр ноён Ж. Бейкер товч үг хэлэв. Мөн нээлтийн үеэр АНУ-ын Элчин сайдын яамны дэргэдэх цэргийн атташе Майкл Бэрнсийг БНМАУ-ын Зэвсэгт хүчний ерөнхий штабын дарга, Батлан хамгаалахын тэргүүн дэд сайд, хошууч генерал Р. Гаваа албан ёсоор хүлээн авч уулзаж ярилцав.

— Америкийн их сургуулийн профессор Х. Шварц, төвийн зарим Хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнууд, улс төрийн нам, эвсэл, холбоодын төлөөлөгчидтэй уулзаж, Монгол улсын Их Цааз (Үндсэн хууль)-ын төслийн талаар санал сэтгэгдлээ хэлэв.

8-р сар

— АНУ-аас Монголын ард түмэнд бэлэглэсэн 207 нэр төрлийн 30 шахам тонн эм, эмнэлгийн барааг хүлээлгэн өгөх ёслол болов.

— Дэлхийд алдартай төрөл бүрийн шошго хэвлэдэг жижиг оврын машин үйлдвэрлэдэг «Шон Мануфактур Инк» пүүсийн төлөөлөгчдийн газар Улаанбаатар хотод ажиллах болов. Тус газар янз бүрийн дүрс чимэглэл, хэмжээтэй цавуутай шошгыг олон өнгөөр, чанарын өндөр төвшинд хэвлэхийн зэрэгцээ машин, тоног төхөөрөмжөө олон улсын зах зээлд зуучлан сурталчилж борлуулдаг байна.

— Олон улсын хөгжлийн агентлагаар дамжуулан буцалтгүй тусламж олгох тухай АНУ, БНМАУ-ын хоорондын хэлэлцээрт АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагаас БНМАУ-д суух төлөөлөгчийн үүрэг

гүйцэтгэгч Роберт Фридлайн, С. Баярбаатар нар гарын үсэг зурав. Энэ хэлэлцээрийн дагуу манай улсад 10 сая долларын буцалтгүй тусламж олгох бөгөөд үүнийг ирэх өвлийн бэлтгэл хангах, эдийн засгийн бэрх шээлээс гарахад ашиглах болно (Одоогоор АНУ нийтдээ 20 сая долларын тусламжийг үзүүлээд байна).

9-р сар

— Америкийн Хөдөлмөрийн холбоо-үйлдвэрлэлийн үйлдвэрчний эвлэлийн конгрессын Ази— Америкийн чөлөөт хөдөлмөрийн институтийн гүйцэтгэх захирал Чарльз Грей, мөн холбооны гишүүн, Америкийн багш нарын холбооны олон улсын институтийн захирал Давид Дари нар МҮЭ-ийн холбооны Төв Зөвлөл, салбарын үйлдвэрчний эвлэлүүдийн гүйцэтгэх хорооны удирдлагатай уулзаж, Ази—Америкийн чөлөөт хөдөлмөрийн институтээс гадаад орнуудад хэрэгжүүлж байгаа ажил, Америкийн багш нарын үйлдвэрчний эвлэлийн тухай танилцуулав.

— АНУ-ын Энх тайвны корпусын Монголд ажиллах сайн дурын мэргэжилтнүүд тангараг өргөв. Тэд хоёр орны засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу 7-р сард манай оронд хүрэлцэн ирж, монгол хэл заалгаж, орон нутгийн нөхцөл байдал, Монголын соёл, зан заншилтай танилцсан бөгөөд 9-р сарын 16-наас англи хэл, цахим тооцоолуурын сургалтын ажлаа эхэлнэ.

— БНМАУ-ын Худалдаа, хөгжлийн банк Америкийн «Америкэн Экспресс» компанийн бэлэн бус төлбөрийн пайзаар (кредит картаар) 8-р сараас МИАТ нэгтгэлийн тасалбар түгээгүүр, «Улаанбаатар» зочид буудал гүйлгээ хийж эхлэв.

— БНМАУ-ын Засгийн газрын шадар сайд Ч. Пүрэвдорж АНУ-ын «Ирсеат» корпорацын төсөл хөгжүүлэх менежер Майл Г. Даулингийг хүлээн авч Монгол орны геологийн тогтоц, ашигт малтмалын тухай багц мэдээ боловсруулах талаар санал солилцов.

10-р сар

— АНУ-ын Батлан хамгаалах Яамнаас Монголд үзүүлж байгаа хүмүүнлэг тусламжийн 2-р ээлжийн бараа болох түргэн тусламжийн 8 машин, эм, оёдлын материал, нийт 500-гаад мянган долларын зүйл Америкийн цэргийн «О—5А» Тээврийн онгоцоор ирснийг хүлээж авав.

— Хандивлагч орнуудын зөвлөлдөх уулзалт Улаанбаатар хотноо БНМАУ-ын Төрийн ордонд 10-р сарын 9—11-нд болж НҮБ-ын Хөгжлийн программ, Азийн хөгжлийн банк, Олон улсын валютын сан, Дэлхийн банк, Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комисс зэрэг олон улсын арван байгууллага болон АНУ, Япон, Англи, Герман зэрэг 16 улсын төлөөлөгчид оролцов. АНУ-ын Засгийн газрын төлөөлөгч Р. Фобер нь Монгол улс ардчилал шинэчлэлийн үйлсдээ үнэнч байна гэсэн найдлага төрүүлж байна гэж тэмдэглээд 1991 оны 10, 11-р сард 2 сая долларын техникийн тусламж үзүүлэх бөгөөд цаашид энэ тусламжаа 4 сая долларт хүргэнэ. Мөн 1,7 сая долларыг эрчим хүч, уул уурхай, газрын тос гэсэн гурван чухал салбарын судалгаа явуулахад зориулна гэж хэлэв.

— АНУ, Монголын бизнесийн зөвлөлийн анхны хуралдаан 10-р сарын 31-нд Вашингтон хотноо болж, Америкийн 50 пүүс компани болон Төрийн департамент, Олон улсын хөгжлийн агентлаг, худалдаа, хөгжлийн программ, Экспорт-импорт банк, Хилийн чанад дахь хувийн хөрөнгө оруулалтын корпорац, Худалдааны департамент, Дэлхийн банк, Олон улсын валютын сан, НҮБ-ын хөгжлийн программ зэрэг байгууллагын төлөөлөгчид оролцов. Бизнесийн зөвлөл нь Монголд хөрөнгө оруулах бололцоо нөхцөлийн талаар АНУ-ын компаниудад дэл-

гэрэнгүй танилцуулсны дараа АНУ-ын Төрийн нарийн бичгийн даргын эдийн засаг, хөдөө аж ахуйн асуудал хариуцсан туслахын орлогч Р. Фобер, Дэлхийн банкны газрын дарга С. Бурки нар үндсэн илтгэл тавьж, бусад байгууллага, пүүсийн төлөөлөгчид саналаа солилцов.

11-р сар

— «Монгол урлаг» пүүс, Америкийн «Ринлинг Брос Барнум бейли цирк» пүүстэй байгуулсан гэрээний дагуу Улсын ардын дуу бүжгийн чуулгын 16 бүжигчин, Улсын циркийн 24 жүжигчин АНУ-д хоёр жилийн хугацаатай айлчлах бөгөөд АНУ-ын бүх муж улсад очиж тоглолтоо сонирхуулна.

— АНУ-ын Ерөнхийлөгч Ж. Буш «Худалдааны харилцааны тухай БНМАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрт» 11-р сарын 13-нд гарын үсэг зурснаар уг хэлэлцээр хүчин төгөлдөр болов.

— БНМАУ-аас АНУ-д суух Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд Л. Даваажав АНУ-ын Ерөнхийлөгч Жорж Бушт 11-р сарын 25-нд Итгэмжлэх жуух бичгээ барив.

— БНМАУ-ын Засгийн газар, АНУ-ын Засгийн газар хоорондын Худалдааны хэлэлцээрийг АНУ-ын Засгийн газар баталсан тухай нотыг тус улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд Ж. Лейк БНМАУ-ын Гадаад харилцааны сайд Ц. Гомбосүрэнд 11-р сарын 27-нд гардуулав. БНМАУ-ын Засгийн газар эл хэлэлцээрийг баталсан тухайгаа Америкийн талд 4-р сард албан ёсоор мэдэгдсэн юм. Ийнхүү нот солилцсоноор хэлэлцээр 1991 оны 11-р сарын 27-ноос хүчин төгөлдөр болов.

— 11-р сарын сүүлийн хоёр долоо хоногт АНУ-ын болон Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын буцалтгүй тусламж — нэг сая долларын эм, эмнэлгийн бараа ирэв.

12-р сар

— Азийн сангийн шугамаар Улсын Бага Хурлын ивээл дор сонгуулийн тогтолцооны талаар семинарт АНУ-ын Холбооны сонгуулийн хорооны удирдлагын хэлтсийн дарга У. Кандермыг оролцов.

— Социалист системийн орнуудад дэмжлэг үзүүлэх зорилгоор АНУ-ын пүүсүүдийн байгуулсан «Перестройка интернейшнл» корпорацын төлөөлөгчид манай улсад ирж, хамтын ажиллагааны талаар тодорхой тохиролцоонд хүрэв. Америк, Европын пүүсүүд, иргэд хамтран олон улсын тусгай орлогын сан байгуулж, Монголд буцалтгүй тусламж үзүүлэх саналыг «Перестройка Интернейшнл»-ээс дэвшүүлэв. Мөн Монголд болсон байгалийн гамшгийн үр дагавартай тэмцэхэд тус байгуул лагаас туслахаа мэдэгдэв.

Хэвлэлд бэлтгэсэн **Б. Энхжаргал**